



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

7 дугаар баг, Эрдэнэбулган сум,
Архангай аймаг, 65143
Утас/Факс: (976) 7033 2780,
Цахим шуудан: info@arkhangai.namem.gov.mn
Цахим хуудас: http://arkhangai.namem.gov.mn

2025.06.05 № 01196
танай 2025.02.10 -ны № 36 -т

Албан шаардлагын хэрэгжилтийн тухай

Байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын албан шаардлагуудын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 07 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу байгууллагын Дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулж, түүний ажиллах журам, 2025 оны жилийн ажлын төлөвлөгөөг тус тус баталсан.(Нэгжийн ажлын тайланг хавсаргав.)

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн санал , дүгнэлтийг үндэслэн 2025 оны А/14 дугаар тушаалаар автомашины шатахуун зарцуулалтын нормыг шинэчлэн тогтоож мөрдөж байна.

3. 2026 оны төсвийн төсөлд цалингийн сангаас олгогддог нэмэгдэл цалин, урамшууллын хэмжээг тооцож тусган, холбогдох тайлбар, санал хүсэлтийг Цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлсэн.

4. Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг тус тус мөрдөн ажиллаж байна.

Холбогдох баримтыг хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт 27 хуудастай.

ДАРГА



Б.БУЛГАНБААТАР

652504017

[illegible][illegible][illegible][illegible]

مستمر (جستجوئی مداوم) و ب. هیستوسیتوم





АРХАНГАЙ АЙМАГ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 Оны 03 сарын 14 өдөр

Дугаар 408

Эрдэнэбулган сум

Дотоод хяналт шалгалтын нэгжийг
байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгжийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Нэгжийн ахлагч: -Уур амьсгалын үйлчилгээ хариуцсан технологич инженер


Гишүүд: -Гадаргын ус судлал хариуцсан технологич инженер,
-Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйлчилгээ хариуцсан
технологич инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн ажилтан
-Нисэхийн мэдээлэл хариуцсан урьдчилан мэдээлэхийн
инженер
-Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологи
инженер
-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан
ажилтан

Нарийн бичгийн

Дарга: -Хүний нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор, жилийн ажлын төлөвлөгөөг тухай бүр тус тус боловсруулж батлуулахыг Дотоод хяналт шалгалтын нэгж (Ц.Өлзийсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БУЛГАНБААТАР

652501021



АРХАНГАЙ АЙМАГ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/17

Эрдэнэбулган сум

Байгууллагын дотоод хяналт шалгалтыг
зохион байгуулах журам батлах тухай


Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3, 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


3. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, тухайн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан, тайлагнаж ажиллахыг дотоод хяналт шалгалтын нэгж (Ц.Өлзийсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БУЛГАНБААТАР

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн
даргын 2025 оны 04 дүгээр сарын 21 -ны
А/17 дүгээр тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын нийтлэг зорилго нь Ус цаг уур, орчны шинжилгээний төв (цаашид "Төв" гэх)-ийн хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" болон холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

Хоёр.Зорилго

2.1. Дотоод хяналт, шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нийтэд үзүүлж байгаа ажил үйлчилгээ, мэдээ мэдээлэл, ажиглалт шинжилгээ, санхүүгийн ил тод байдал түүний явуулж байгаа үйл ажиллагаа зэрэг нь дээд газрын тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, аливаа эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

2.2. Дотоод хяналт, шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, төвийн үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.

Гурав. Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нэгжийн эрх

3.1. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг төвийн дотоод хяналтын нэгж гүйцэтгэнэ.

3.2. Дотоод хяналт шалгалтын нэгж нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна

3.3. Дотоод хяналт шалгалтыг төвийн даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.

3.4. Тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан төвийн даргаар батлуулан мөрдөж ажиллана.

3.5. Дотоод хяналт шалгалтын явцад холбогдох албан тушаалтнаар шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулж ажиллана.

3.6. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

3.7. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.8. Холбогдох дүрэм, журам, байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журмуудыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын нэгжийн хүлээх үүрэг

4.1. Хяналт шалгалт зохион байгуулсан нэгж нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсэх, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлж, арга зүйн зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулж дүнг тайлагнаж ажиллана.

4.2. Дотоод хяналт, шалгалтаар төвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх, удирдлагыг мэдээллээр хангах

4.3. Дотоод хяналт, шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгуулах, асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах

4.4. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж, биелэлт гаргаж тайлагнах

4.5. Шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг бүртгэх, дотоод хяналт шалгалтын чиглэлийн материалыг эмхэлж, цэгцлэн хөтлөлт хийн байгууллагын архивд нэгж болгон хүлээлгэн өгөх

4.6. Дотоод хяналт шалгалт зохион байгуулсан нэгж нь хяналт шалгалтын ажлын явцад аливаа эрсдэлээс хамгаалах, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч дүн шинжилгээ хийж, авсан арга хэмжээний талаар нэгээс доошгүй удаа төвийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

4.7. Дотоод хяналт шалгалтын чиглэлээр мэдээ мэдээллийг хамт олонд хүргэж, сургалт сурталчилгаа зохион байгуулах

Тав. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

5.1 Монгол Улсын хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэр, байгууллагын дүрэм, дотоод журмаар хүлээсэн үүргийн хүрээнд хяналт шалгалт хийнэ. Үүнд:

5.1.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй захирамжлалын баримт бичиг, албан хэргийн шийдвэрлэлт иргэд аж ахуй албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бодлогын баримт бичиг, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандарт, бусад эрх зүйн бичиг баримтын хэрэгжилт;

5.1.2 Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль (Цаашид ЦУОХШТХ), Технологийн сахилгын дүрэм, байгууллагын дотоод журам бусад хууль тогтоомжийн хэрэгжилт;

5.1.3 Байгууллагын хэлтэс, салбар, ус, цаг уурын өртөө, харуулын шинжилгээний ажлын технологийн мөрдөлтийн хэрэгжилт;

5.1.4 Цаг уурын ажиглалт, мэдээ, мэдээлэл үйлчилгээний чанар, хүртээмж;

5.1.5 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын биелэлтэд хяналт тавих

5.1.6 Өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5.1.7 Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэл, идэвх оролцоо, ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх

5.1.8 Өрөө тасалгааны эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээ;

5.1.9 Байгууллагын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлт;

5.1.10 Байгууллагын доторх нэгж, хэсэг, өртөө, харуулын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт;

5.1.11 Хэлтсийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, тайлагналт, үр дүнг үнэлж байгаа байдалд хяналт шалгалт хийх

Зургаа. Хариуцлага

6.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал гаргасан буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

6.2. Байгууллагын удирдлага нь дотоод хяналт шалгалтын нэгжийн саналыг үндэслэн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

6.3. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

БАТЛАВ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА Б.БУЛГАНБААТАР

2025 оны 04 дүгээр сарын 29

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖИЙН
2025 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 04 дүгээр сарын 29

Эрдэнэбулган сум

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хяналт шалгалтад хамрагдах нэгж, албан тушаалтан	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4	5
Зорилт-1. Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй захирамжлалын баримт бичиг, албан хэргийн шийдвэрлэлт иргэд аж ахуй албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бодлогын баримт бичиг, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандартууд бусад эрх зүйн бичиг баримтын хэрэгжилт;				
1.1.	Тушаал, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах	Захиргаа санхүү аж ахуйн хэлтэс хүний нөөц, архив, бичиг хэрэг	Улирал бүр	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга
1.2.	Байгууллага, хэлтэс, нэгж, бүх ажилчдын хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгах	Хэлтсүүд	6 дугаар сарын 02 11 дүгээр сарын 25	Дотоод хяналт шалгалтын нэгж бүрэлдэхүүн
1.3.	Албан хаагчдын хугацаатай албан бичиг мэдээ тайланг хүргүүлэх ажлыг хангуулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөлтийг хянан шалгах	Хэлтсүүд	6 дугаар сарын 02 11 дүгээр сарын 25	Дотоод хяналт шалгалтын нэгж бүрэлдэхүүн
1.4.	Байгууллагын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хянан шалгах	Хэлтсүүд	Улирал бүр	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга
1.5.	Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сургалт, цаг үеийн, олон нийтийн ажилд оролцсон байдлыг хянан шалгах	Хэлтсүүд, сарын ажил хариуцсан салбар	Сар бүр	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга
1.6.	Өрөө тасалгааны эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээг хянан шалгах	Захиргаа санхүү аж ахуйн хэлтэс	Улирал бүр	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга
1.7.	Байгууллагын Баримт нягтлан шалгах байнгын зөвлөлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хянан шалгах	Захиргаа санхүү аж ахуйн хэлтэс хүний нөөц, архив, бичиг хэрэг	Жилдээ	Дотоод хяналт шалгалтын нэгж бүрэлдэхүүн
1.8.	Дотоод хяналт шалгалтын нэгжийн бүрэлдэхүүнийг чадваржуулах танхим болон цахим сургалтад хамруулах	Дотоод хяналт шалгалтын нэгжийн бүрэлдэхүүн	4 дүгээр сард	Дотоод хяналт шалгалтын нэгжийн ахлагч Ц.Өлзийсайхан
Зорилт-2 Ус, уур орчны хяналт шинжилгээний тухай хууль, технологийн сахилгын дүрэм, байгууллагын дотоод журам бусад заавар дүрэм журмын биелэлтийн хэрэгжилт;				
2.1.	Ус, цаг уурын өртөө харуулын шинжилгээний ажлын технологи мөрдөлтөд хяналт шалгалт хийх	Цаг уур орчны технологийн хэлтэс ус, цаг уурын өртөө	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгжийн бүрэлдэхүүн

1	2	3	4	5
		харуул (Цаг уур, ХААЦУ, Ус судлал, БОШЛ, АМДСан)		
2.2.	Ус, Цаг уурын мэдээ, мэдээлэл, өртөө харуулын ажиглалтын горимын мэдээний үр дүнд хяналт шалгалт хийх	Мэдээлэл үйлчилгээний хэлтэс (Цаг уур, ХААЦУ, Ус судлал, БОШЛ)	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгж бүрэлдэхүүн
2.3.	Байгууллагын дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг шалгах	Хэлтсүүд	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгж бүрэлдэхүүн
Зорилт-3 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, байгууллагын дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт:				
3.1.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгж
3.2.	Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хяналт шалгалтын хуудас 2 11-ээр шалгах	Байгаль орчны шинжилгээний лаборатори, Цаг агаарт зориудаар нөлөөлөх Цэцэрлэг бороо-1 эксцениц, ус, цаг уурын өртөө, харуул	2,3-р улиралд	Дотоод хяналт шалгалтын нэгж
Зорилт-4 Өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын хэрэгжилт				
4.1.	Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийх	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс	V/5-20 дотор сумдын өртөө, харуулд XI/1-30-ны төвийн салбаруудад	Дотоод хяналт шалгалтын нэгж
4.2.	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн хэсэг Өмч хамгаалах байнгын зөвлөл	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгж
4.3.	Санхүүгийн шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалт хийх	Санхүүгийн хэсэг	Улирал бүр	Дотоод хяналт шалгалтын нэгж
Зорилт-5 Байгууллагын доторх нэгж, хэсэг, өртөө, харуулын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, үнэлэлт дүгнэлт өгөх				
5.1.	Цаг уур орчны технологийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Цаг уур орчны технологийн хэлтэс	5.6 саруудад	Дотоод хяналт шалгалтын нэгж
5.2.	Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Мэдээлэл үйлчилгээний хэлтэс	6 сард	Дотоод хяналт шалгалтын нэгж
5.3.	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс	Жилдээ	Дотоод хяналт шалгалтын нэгж

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖИЙН
АХЛАГЧ *Janaa* Ц.ӨЛЗИЙСАЙХАН

БАТЛАВ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА Б.БУЛГАНБААТАР

2025 оны 25 дугаар сарын 07

УДИРДАМЖ

2025 оны 5 дугаар сарын 07

Эрдэнэбулган сум

Зорилго. Байгууллагын өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны мэдээлэл, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сургалт, цаг үеийн болон олон нийтийн ажлын оролцоог хянан шалгах, аливаа эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх.

Хамрах хүрээ: Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаа, нярав Ч.Оюунтуяа (санхүү), Хүний нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга

Хяналт, шалгалт хийх бүрэлдэхүүн: Байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж

Хугацаа:

2025 оны 5 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд

Нэг. Гүйцэтгэх ажил

Санхүүгийн чиглэлээр:

1. Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологи хариуцсан технологич инженерийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын картын тулгалт, ашиглалт, хамгаалалт
2. Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженерийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын картын тулгалт, ашиглалт, хамгаалалт
3. 1-4 саруудын санхүүгийн шилэн дансны мэдээлэл

Дотоод ажил үйлчилгээний чиглэлээр:

1. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сургалт, цаг үеийн болон олон нийтийн ажлын оролцооны бүртгэл тооцоо, авсан арга хэмжээ

Хоёр. Хяналт, шалгалтын үр дүнг танилцуулж, баталгаажуулах

1.Нэгжийн хяналт шалгалтанд хамрагдсан ажилтан, албан тушаалтанд ажлын ололттой тал, сул талыг тогтоон илрүүлж, илтгэх хуудсаар танилцуулан, баталгаажуулна.

2.Нэгжийн хяналт шалгалтанд хийсэн тайлан, санал, дүгнэлтийг төвийн даргад танилцуулах,

3.Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг ажилтан, албан хаагчдад хүргүүлэх

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

НЭГЖИЙН АХЛАГЧ

Ц.Өлзийсайхан Ц.ӨЛЗИЙСАЙХАН

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН

2025 оны 5 дугаар сарын 19

Эрдэнэбулган сум

Зорилго. Байгууллагын өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны мэдээлэл, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сургалт, цаг үеийн болон олон нийтийн ажлын оролцоог хянан шалгах, аливаа эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгч, Нэгжийн хяналт шалгалтанд хамрагдсан ажилтан, албан тушаалтанд ажлын ололттой тал, сул талыг тогтоон илрүүлж, илтгэх хуудсаар танилцуулан, баталгаажуулж, тайлан, санал, дүгнэлтийг төвийн даргад танилцуулах.

Хамрах хүрээ: Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаа, нярав Ч.Оюунтуяа (санхүү), Хүний нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга нарын ажил үүргийн хамруулан байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж 2025 оны 5 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд хийлээ.

Хяналт шалгалтаар Хүний нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул сургалттай байсан тул түр орлон ажилласан Б.Гантулгаас зарим холбогдох мэдээллийг гаргуулан авлаа.

Давуу тал:

Санхүүгийн салбар (хэсэг)-албан хаагч бүр дээр эд хөрөнгийн бүртгэл хяналтын карт нээгдсэн, shilendans.gov.mn сайтад тавигдах мэдээ, мэдээлэл бүрэн тавигдсан, Төвийн албан хаагчид төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системээр цагаа бүртгүүлж хэвшсэн байна.

Нэг. Байгууллагын өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтын чиглэлээр,

1. Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологи хариуцсан технологич инженер, байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер нарын эд хөрөнгийн бүртгэл хяналтын картын тулгалт, ашиглалт, хамгаалалт шалгалаа.

Үүнд:1. Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологи хариуцсан технологич инженерт 30 нэр төрлийн 86,168,901.98 төгрөгийн эд хөрөнгө бүртгэлтэй байгаагаас чанарын хувьд ашиглалт, хадгалалт, хамгаалалт дунд байна.

- ❖ АТ-IE мэдрүүрийн шалгагч багаж (Солонгос автомат станцын этолан багаж-45,879,796.00) Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны дугаар-818 тогтоолоор актлагдсанг эд хариуцагчын бүртгэлээс хасаагүй.
- ❖ 2008 онд Эрдэнэмандал, Төвшрүүлэх өртөөдөд суурилуулсан CAMS620 цаг уурын автомат станцууд актлагдсан бөгөөд энэ автомат станцын 9ш мэдрүүрүүд машин тоног төхөөрөмжинд бүртгэгдсэнээр тухай үеийн тооллогын комиссын дүгнэлтээр актахаар явуулсан боловч ТӨБЗХорооноос актах дүгнэлт гараагүй учир бүртгэлтэй байгаа.
- ❖ Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Эрдэнэбулган, Өгийнуур сумын автомат станцын мэдрүүр, төхөөрөмжүүд -7ш өртөө, харуулд тараагдсан байна.

2.Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженерт 53 нэр төрлийн 77,637,637.20 төгрөгийн эд хөрөнгө бүртгэлтэй байгаагаас чанарын хувьд ашиглалт, хадгалалт, хамгаалалт дунд байна.

- ❖ Ашиглагдахгүй байгаа -1 ш (Тоосны сорьц авагч багаж)
- ❖ Солих шаардлагатай сав, никель түмпен-3ш, хөргөгч-1ш байна.

2. shilendans.gov.mn 1-4 саруудын санхүүгийн шилэн дансны мэдээлэлд shilendans.gov.mn сайтад мэдээлэлд хугацаандаа бүрэн тавигдсан байна.

	Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	И-ийнх: n10@arkhangai.gov.mn/ Авчлын үтэс: 70332750	Шуудангийн хаяг: Сохиол хянг, Архангай Цэг Уур	Далгаваргүй мэдээлэл
				Салбар байгууллагууд

Дэлгэрэнгүй мэдээлэл
Салбар байгууллагууд

[illegible]

Хүндэтгэсэн үндсэн баримт дүгнэлт хамт хуудсугаар тавьж, дүгнэлт болон
бүтээгч эхнэрийг цаасан дээр нь оруу.



Архангай аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

И-мэйл:
info@arkhangai.nemelt.gov.mn
Ажлын утас:
70332780

Шуудангийн хаяг:
Орхон-Уул хаяг
Архангай Цэгүүд

Далгаваргүй мэдээлэл
Салбар байгууллагууд

Тайлбарын жил: 2024

Нийт хэмжээ: 111
Тэмдэглэгдэж эхлэв тайлбар

Төслийн байгууллага



Төсөл, гүйцэтгэл			Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт		Бусад											
№	Тайлбарын нэр	Ирээдүйний жил	Мэдээлэл оруулсан үйлчилгээ	Төлөв	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сайт-ийн			Сайт-ийн нэр	Сайт-ийн нэр												
1	Төслийн байгууллагын баталсан төсөл, гүйцэтгэл - Хөдөлбөр, зориулалт		Дарал Салбар 8-ны дотго	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төслийн байгууллагын баталсан төсөл, гүйцэтгэл - Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт		Дарал Салбар 8-ны дотго	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Хөдөлбөр, зориулалт																
3	Самууныг тайлбар		Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт	*						✓						
4	Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт		Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт	*						✓						
5	Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт		Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт - Хөдөлбөр, зориулалт	*						✓						

Хоёр: Дотоод ажил үйлчилгээг чиглэлээр:

А. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сургалт, цаг үеийн болон олон нийтийн ажлын оролцооны бүртгэл тооцоо, авсан арга хэмжээ

Төвийн албан хаагчид төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системээр цагаа бүртгүүлж хэвшсэн бөгөөд БОШЛ-ын инженер, техникч нар богиносгосон цагаар, УМИнженерүүд, Цэцэрлэг өртөөний ээлжийн ажиглагч нар ээлжийн гараагаарай болон (ээлжийн ажлын хуваарь график) цаг бүртгүүлж байна.

1-4 дүгээр сарын ажлын цагийн бүртгэл



Цагийн бүртгэлээс харахад захиргаа, санхүү аж ахуйн албан хаагчид хамгийн сайн буюу 95%-тай, цаг уур, орчны технологийн хэлтэс 30-1 цагийн хоцролттой, мэдээлэл үйлчилгээний хэлтэс ээлжийн бүртгэлтэй бүртгэгдсэн байна. Ирц бүртгэлээр 1 инженер, 1 техникч 4 сарын нийлбэрээр 1 цагаас дээш хоцролттой байсан тул хэлтсийн дарга болон албан хаагчдад биечлэн танилцуулсан.

Б. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажлын чиглэлээр

Олон нийтийн ажлын оролцооны бүртгэлээр 9 удаагийн ажил үйлчилгээ явагдсан бөгөөд нийт албан хаагчдын хамруулсан 2 удаагийн хуралд албан хаагчид 98.0%, төвийн албан хаагчид 98.8%, дунджаар 98.4%-тай оролцсон байна.

№	Тайлбар	Хог шүүрлэгээ 2025.01.06	Хог шүүрлэгээ 2025.02.21	Хог шүүрлэгээ 2025.03.17	04.04 Байгууллага хурал	04.05 хог шүүрлэгээ	04.10 Хөдөлмөр хамгааллын нээлттэй таалалны өдөр	04.12 шүүрлэгээ	04.13 хоол хийх үйлчлэл	04.21 нийгмийн даатгал сургалт	Дундаж дүн, хуви
1	Б.Булганбаатар	100	40	100	100	100	100	100	100	100	100
2	Г.Гэрэлмаа	40	40	100	100	100	100	100	100	100	100
3	Ц.Бямбарсүх	авчтай	40	100	100	100	0	100	100	0	98
4	Ч.Бямбасүрэн	100	100	100	100	100	0	100	100	100	99
5	Э.Бадрах	100	100	100	100	100	таалалтай	100	100	100	100
6	Д.Их-Оюун	100	100	100	100	100	40	100	100	100	100
7	Ц.Өлзийсайхан	100	100	100	40	100	100	100	100	100	100
8	Э.Милгэржаргал	100	100	100	100	100	40	40	40	100	100
9	Д.Уранчимэг	100	100	100	100	100	100	100	100	100	100
10	Ц.Зулааза	100	100	100	100	100	100	100	100	100	100
11	Г.Ариунтүвшин	100	100	100	100	100	100	100	100	100	100
12	У.Шуранчимэг	100	100	100	100	100	100	100	100	100	100
13	Т.Бямбаржаргал	100	100	100	100	100	100	100	100	100	100
14	М.Чулуунхүү	100	100	100	100	100	100	авчтай	авчтай	100	100
15	Ч.Оюунтуяа	100	40	100	авчтай	авчтай	0	авчтай	авчтай	100	99
16	Б.Гантулга	100	100	100	100	100	100	100	100	100	100
17	А.Хашчимэг	100	40	100	100	0	100	100	100	100	99
18	Д.Сэрэнгэрэл	40	100	100	0	100	0	100	100	0	98
19	Н.Оюунбаяр	0	100	100	0	0	гараатай	100	100	0	96
20	М.Эрдэнэчулуун	100	0	100	100	0	100	0	100	0	96
21	Б.Наранцагдэл	0	0	100	0	0	100	100	гараатай	0	95
22	Р.Жанлаабазар	0	0	100	0	100	100	100	100	100	97
23	Н.Отгонбаатар	0	100	100	0	100	100	100	0	100	97
24	С.Оюунбат	100	100	100	100	100	100	100	100	100	100
25	Б.Бямбасүрэн	100	0	100	100	100	100	100	100	100	99
26	Б.Мөнхбаяр	0	100	100	0	100	0	авчтай	0	100	96
27	С.Мөнхтөр	100	100	100	0	100	0	100	авчтай	100	96
28	П.Чанцалдулам	100	100	100	100	0	гараатай	100	100	100	99
29	Ш.Отгонсамбуу	100	100	100	100	40	100	100	100	100	100
30	Д.Гантуул	100	100	100	100	40	40	40	100	100	100
31	М.Энх-Амгалан	100	100	0	100	100	0	100	100	100	98

32	Ж.Болдсайхан				100						100
33	Г.Сүхмороо				100						100
34	В.Бадрах				100						100
35	Б.Амгалан				100						100
36	П.Зулааза				100						100
37	Б.Амгалан				0						98
38	Б.Бямбасүрэн				0						98
39	Г.Эрдэнэчулуун				100						100
40	В.Оюунсүрэн				40						100
41	Д.Ариунтүвшин				100						100
42	М.Бямбаржаргал				авчтай						100
43	Ц.Батымэг				100						100
44	Т.Төгсжаргал				100						100
45	М.Баясгалан				100						100
46	Р.Эрдэнэчимэг				100						100
47	Э.Амаржаргал				0						98
48	Б.Амгалан				100						100
49	Р.Увсдулам				0						48
50	Ж.Энхжаргал				100						100
51	Д.Юмжирдулам				100						100
52	Чойном				100						100
53	Б.Оюун-Эрдэнэ				100						100
54	О.Одооимуг				100						100
55	Т.Ганцмэг				100						100
56	Н.Наранцагт				100						100
57	Б.Амгалан				0						48
58	Ч.Түвшин				100						100
59	Б.Сүхмороо				100						100
60	Б.Амгалан				0						0
61	Д.Жаргалдулам				100						100
62	Ч.Энхжаргал				100						100
63	Н.Амгалан				100						100
64	Д.Амгалан				100						100
65	Л.Бадрах				100						100
66	М.Амгалан				100						100
67	Б.Оюунимуг				0						48

Shilen.gov.mn буюу байгууллагын нээлттэй ил тод байдлын мэдээллийн үйл ажиллагаа 30%-ийн гүйцэтгэлтэй байна.





Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болох Өрөө, тасалгааны эмх цэгч, цэвэрлэгээ үйлчилгээг хянан шалгаж албан хаагчдаас googleforms-оос Өрөө тасалгааны эмх цэгч, цэвэрлэгээ үйлчилгээг хянан шалгах судалгааг авахад нийт 66 албан хаагчаас 50 албан хаагч оролцож 75.8 хувьтай оролцлоо.

Өрөө тасалгаа нь эмх цэгцтэй байдаг уу?

Copy chart

50 responses



Цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийдэг үү?

Copy chart

50 responses



Эмх цэгцтэй байдал дээр тийм 74% хувьтай буюу дунд, Цэвэрлэгээ үйлчилгээ 88%-тай сайн гэж үнэлэгдлээ.

Гурав. Дүгнэлт

1. Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилт хэвийн сайн байна.
2. Албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийн картыг дансны нэр, бүлэг, төрлөөр хөтлөөгүй. (бараа, материал, машин тоног төхөөрөмж гэх мэт) баяжилтыг тухай бүр хийгээгүй.
3. Албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийн картанд холилдож бүртгэгдсэн
4. Ирсэн эд хөрөнгө, бараа материалыг авчирсан хүлээн авч, авчирсан хүмүүс нэг бүрчлэн тулгаж няравт орлого зарлагын баримт болон бусад холбогдох материалын хамт хүлээлгэн өгөгдөггүй.
5. Байгууллагын нээлттэй ил тод байдлын мэдээллийн Shilen.gov.mn сайтын үйл ажиллагаа хангалтгүй хөтөлсөн. (Ямар мэдээллийг хэн хэрхэн гаргаж өгөх талаар хариуцсан ажилтан албан хаагчдад танилцуулан мэдээллээ авч байршуулах ажлыг зохион байгуулах М.Энх-Амгалан)
6. Төвийн албан хаагчид төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системд ээлжийн ажилчдын цагийн бүртгэлийг бүрэн бүртгэх судлан цагийн бүртгэлийг жигдрүүлээгүй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
НЭГЖИЙН АХЛАГЧ

Ц.Өлзийсайхан

Ц.ӨЛЗИЙСАЙХАН

ГИШҮҮД:

П.Чанцалдулам

П.ЧАНЦАЛДУЛАМ

Ш.Отгонсамбуу

Ш.ОТГОНСАМБУУ

У.Шүрэнчимэг

У.ШҮРЭНЧИМЭГ

М.Чулуунхүү

М.ЧУЛУУНХҮҮ

Б.Гантулга

Б.ГАНТУЛГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.Гантуул

Д.ГАНТУУЛ

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ
БАТАЛГААЖУУЛСАН:

Г.Гэрэлмаа

Г.ГЭРЭЛМАА

Ч.Оюунтуяа

Ч.ОЮУНТУЯА

Б.Гантулга

Б.ГАНТУЛГА

Д.Гантуул

Д.ГАНТУУЛ



АРХАНГАЙ АЙМАГ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/14

Эрдэнэбулган сум

Авто машины шатахуун зарцуулалтын
нормыг шинэчлэн тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Автомашинны шатахуун зарцуулалтын жишиг нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж", Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, санал дүгнэлт, төвийн даргын дэргэдэх зөвлөлийн 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архангай аймгийн төрийн аудитын газрын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 33/A0370220 АРА-2025/51/НА-СТА-ТШЗ дугаар "Зөрчил арилгах тухай" албан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа Мицубиши L-200 маркын авто машины 100 (нэг зуу)-н километр зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг хүйтний улиралд 20 (хорь)-н литрээр, дулааны улиралд 15 (арван тав)-н литрээр тус тус тогтоосугай.

2.Дээрх шатахууны нормыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллахыг Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаад зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл (Д.Их-оюун)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БУЛГАНБААТАР

652501049

**АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар №01

Цэцэрлэг хот

Архангай аймгийн Төрийн Аудитын газрын 2025 оны 02 дугаар сарын 10 өдрийн 33/А0370220 /АРА-2025/51/НА/СТА/ТШЗ дугаартай албан шаардлагын дагуу Зам тээврийн хөгжлийн сайдын 390-р дугаар тушаалын 3-р хавсралтаар баталсан 99-р тооцоолол хийхээр өмч хамгаалах комисс Мицубиши L200 автомашины шатахуун зарцуулалтын норм нормативын журмын дагуу тогтоож мөрдөх тухай хурлыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 15 цагаас 04 минутаас 16 цаг 54 минутын хугацаанд 202 тоот өрөөнд хэлэлцэв.

Хуралд:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга: Цаг Уур Орчны Технологийн хэлтсийн дарга Д.Их-Оюун даргалав.

Өмч хамгаалах: Нарийн бичгийн даргаар Ш.Отгонсамбуу Мэдээллийн сан хариуцсан технологич инженер

Гишүүд: Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаа,

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер С.Мөнхтөр,

Нярав, аж ахуйн туслах ажилтан Ч.Оюунтуяа нар хуралд оролцов. Ирц 100 хувьтай.

Нэмэлтээр:

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны Техникч- Жолооч Э.Бадрах

ХЭЛЭЛЦЭХ нь:

Архангай аймгийн Төрийн Аудитын газрын 2025 оны 02 дугаар сарын 10 өдрийн 33/А0370220 /АРА-2025/51/НА/СТА/ТШЗ дугаартай албан шаардлагын дагуу Зам тээврийн хөгжлийн сайдын 390-р дугаар тушаалын 3-р хавсралтаар баталсан 99-р тооцоолол, өмч хамгаалах комисс Мицубиши L200 автомашины шатахуун зарцуулалтын норм нормативын журмын дагуу тогтоож мөрдөх тухай

Хурлаар асуудлыг ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаа танилцуулав.

Манай төвд ашиглагдаж байгаа Мицубиши L200 автомашин нь 2019 онд 00 километрийн гүйлттэй ирж байсан ба 2020 оны 05 дугаар сарын 01-нээс албан ажилд ашиглаж эхэлсэн. Зам тээврийн Хөгжлийн сайд 390-р тушаалын 01-р хавсралтанд заасан автомашины марк, загварын жагсаалтанд Мицубиши L200 автомашин нь 2477 хөдөлгүүрийн багтаамжтай дизель хөдөлгүүртэйгээр орсон байдаг. Манай байгууллагад ашиглагдаж байгаа Мицубиши L200 автомашин нь хөдөлгүүрийн багтаамж нь 2500 хөдөлгүүрийн багтаамжтай, өөрийн жин 1715 кг, бүх жин 2315 кг, шатахуун зарцуулалт нь бензин АИ-92 байна. Тухайн ашиглаж эхэлсэн өдрөөс дулааны улиралд 100км-т 15 литр, Хүйтний улиралд 100км-т 20 литр шатахуунаар тооцож олгож байна.

Хурлын дарга Д.Их-Оюун: Дээрх Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаагийн тооцож олгосон шатахуун бодит байдал дээр зарцуулалт ямар байгаа талаар Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны Техникч- Жолооч Э.Бадрах тайлбар өгнө үү.

Техникч- Жолооч Э.Бадрах: Манай байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж Мицубиши L200 автомашинаар ихэнхдээ орон нутгийн зам болон сум багийн бартаа ихтэй, уул хадаар явдаг. Жишээ нь: Өвлийн явуул судалгаанд явахдаа цастай буюу зудтай газар нутгийг сонгож хээрийн цасны хэмжилтийг хийдэг.

Хавар, Зун, Намрын улиралд Архангай аймгийн нутаг дэвсгэрт Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд явахдаа замгүй, мөн суурин газраас 15 км, хот айл, хүн малаас 5 км, зам харилцаа, эрчим хүчний дэд бүтцээс 10 км зайд үйл ажиллагаа явуулдаг. Цаг агаарт нөлөөлөхөд далайн түвшнээс 1500 метрээс дээш өндөрлөгт үүлний шилжин ирэх массыг угааж, дагаж, тосож үйлчилдэг учраас зам харгалзахгүй явдаг.

Өвлийн улиралд Мицубиши L200 автомашин нь Араб стандартаар үйлдвэрлэгдсэн машин учир кабендаа дулаан алдалт их, хойд зааландаа нэмэлт паар байхгүй учир машин унтрах төдийд машины дулаан алдалт их, байнгийн машины хөдөлгүүр асаалттай байдаг, манай байгууллагын ажлын онцлог нь гадна орчинд ажилладаг зэргээс шатахуун их зарцуулагддаг.

Албан ажил гүйцэтгэж явахад төлөвлөгөөгүй замаар явч тооцож олгосон бензин хүрэхгүй тохиолдол олон удаа гарч байсан.

Хурлын дарга Д.Их-Оюун: 2024 оны намар 10 сарын эхээр Баруун хойд сумдад явах чиглэлд тооцсон бензин хүрэлцээгүй мөн цас ихтэй буюу ачаа ихтэй үед 2-3 удаа шар гэрэл асаж жолооч өөрийн мөнгөөр бензин хийж ирж байсан удаатай.

Гишүүн Ш.Отгонсамбуу: 2021 онд зуны явуул судалгааг Цэнхэр буюу Ихтамир сумдад 15 цэгт судалгаа хийх явцад бензин хүрэлцэхгүй байсан удаа байсан шүү.

Гишүүн Ч.Оюунтуяа: 2024 оны 10 сарын 31-нд Чулуут суманд ажил хүлээлцэх ажлаар явж байхад цас ихтэй, халтиргаа гулгаа их бензин хомс байдлаас харгалзан зам дөтлөж явахад эрсдэл өндөртэй байсан. Ерөнхийдөө манай байгууллагад бензины хомсдолтой нөхцөл байнга байдаг.

Гишүүн С.Мөнхтөр: “Цэцэрлэг бороо-1” экспедиц жил болгон хур тунадас нэмэгдүүлэх зорилгоор гол, ус, уул, нуруу, ой мод, хад буюу бартаа ихтэй замаар явдаг учир бензин их зарцуулдаг. Тэр болгон төлөвлөсөн маршрутаа ихэнх тохиолдолд өөрчлөгдөж тооцсон шатахуун тэр бүр хүрэлцэхгүй асуудал цөөнгүй гардаг.

Гишүүн Г.Гэрэлмаа: Өөрийн байгууллагын ажлын онцогт уялдуулж дээрх нөхцөл байдлыг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын бодит хэмжээг дулааны улирал буюу 05 сарын 15-наас 10 сарын 15-ныг хүртэл 100км-т 15 литр, Хүйтний улирал буюу 10 сарын 15-наас 05 сарын 15-ныг хүртэл 100 км-т 20 литр шатахууныг тооцон олгож байгаа. Иймд дээрх нормоор тооцож олгох саналтай байна.

Хурлын дарга Д.Их-Оюун: Манай байгууллагын Мицубиши L200 автомашины бодит шатахуун зарцуулалт 100 км-т дулааны улиралд 15 литр, хүйтний улиралд 100 км-т 20 литрээр тооцож зарцуулахгүй болвол төлөвлөсөн ажлаа гүйцэтгэж чадахгүйд хүрнэ. Иймд энэ нормоор тооцож явах нь зөв юмаа.

Гишүүн С.Мөнхтөр: Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажлын шатахууныг улиралд тохируулан энэ хэвээр нь олгож байхыг дэмжиж байна.

Техникч- Жолооч Э.Бадрах: Жолооч хүн ажлын онцлог, зорчигчдын аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, амь нас, эрүүл мэндийг хариуцдаг хариуцлагатай ажил байдаг. Тийм учраас хөдөө гадаа, цаг агаарын хүнд нөхцөлд замын бартаа саад зэргийг үндэслэн энэ тооцоолсон бодит шатахууныг багасгахыг дэмжихгүй байна.


Хурлын дарга Д.Их-Оюун: Санал хураая.

Архангай аймгийн ус, цаг уур орчны шинжилгээний төвийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүх гишүүд Мицубиши L200 автомашиныг ашиглаж эхэлсэн өдрөөс дулааны улиралд 100км-т 15 литр, Хүйтний улиралд 100км-т 20 литр шатахуунаар тооцож олгож байгааг хэвээр үлдээхийг бүх гишүүд 100 хувийн саналтай дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүх гишүүд 100% саналаар байгууллагын Мицубиши L200 автомашиныг дулааны улиралд 100км-т 15 литр, Хүйтний улиралд 100км-т 20 литр бензинээр тооцож зарцуулахаар шийдвэрлэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТАНИЛЦСАН:



Ш.ОТГОНСАМБУУ
Д.ИХ-ОЮУН



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Э.БАТТУЛГА ТАНАА

7 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65143

Утас: 70332780, Факс: (976) 70332780
Цахим шуудан: info@arkhangai.namem.gov.mn
Цахим хуудас: <http://arkhangai.namem.gov.mn>

2025.04.18 № 01/63

танай _____-ны № _____-т

Хүсэлт хүргүүлэх тухай

Иргэний нисэхийн ерөнхий газар, Цаг уур, орчны шинжилгээний газрын хооронд байгуулсан 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн № 11,24,2024/ЦУ-40 дугаартай "Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх талаар хамтран ажиллах ерөнхий гэрээ"-ний 3 дугаар зүйлийн 3.14-д "Нислэгийн цаг агаарын мэдээгээр үйлчлэх ажлыг хийдэг, ... болон орон нутагт энэ ажлыг хавсран хийдэг синоптик инженер, цаг уурын бодит мэдээний үйлчилгээ хийж буй цаг уурын өртөө, харуулын ажиглагч, техникч нарт ажлын үр дүнг харгалзан сарын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар сар бүр нэмэгдэл олгох"-оор заасан.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу агаарын тээврийн нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсний нэмэгдэл хөлсийг нэг онгоцонд үйлчлэхэд 15.000 (арван таван мянга)-н төгрөгөөр тооцож хагас, бүтэн жилээр олгож байсныг Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны жилийн эцсийн тайланд хийсэн санхүүгийн шалгалтаар төсвийг зориулалт бусаар зарцуулсан, нэмэгдэл хөлс, урамшууллын хэмжээг төсвийн холбогдох зардалд тусгалгүйгээр цалингийн сангаас олгосон хэмээн үзэж "... зөрчлийг таслан зогсоож ирэх жилийн төсөвт нэмэгдэл хөлсийг тооцож тусган батлуулах, зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх" албан шаардлага өгсөн.

Сангийн яамнаас төсвийн төслийг нэгтгэж авч байгаа загвар хүснэгтэд дээрх нэмэгдэл тусгайлан тусгагдаагүй, төлөвлөх боломжгүй байгаа бөгөөд Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын Код 210102 Нэмэгдэл гэсэн зардлын тодорхойлолтод "... , нислэгийн үйлчилгээний, ... нэмэгдэл, нэмэгдэл хөлс багтана." гэж байгаа тул дээрх албан шаардлага, гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой олгох нэмэгдлийг "нислэгийн үйлчилгээний нэмэгдэл" гэдгээр цалингийн нэмэгдэл зардалд тусгайлан тусгах асуудлыг шийдвэрлэж, чиглэл зөвлөмж өгнө үү.



Архангай аймгийн Ус цаг уур, орчны
шинжилгээний төв

Удирдлага

Дарга

Бямбажав Булганбаатар

2025-04-18 14:21:55



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Г ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Э.БАТТУЛГАТАНАА 7

7 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг. 65143

Утас: 70332780, Факс: (976) 70332780
Цахим шуудан: info@arkhangai.namem.gov.mn
Цахим хуудас: <http://arkhangai.namem.gov.mn>

2025.04.25 № 01/74
танай _____-ны № _____-т

Г 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 7
оны төсвийн төсөөлөл хүргүүлэх
тухай

Байгууллагын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төслийн төсөөллийн саналыг маягтын дагуу боловсруулан төслийн танилцуулгын хамт хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.



Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв
Удирдлага
Дарга
Бямбажав Булганбаатар
2025-04-25 17:31:25

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026
ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛСАН ТАНИЛЦУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 25

Эрдэнэбулган сум


2026 оны төсвийн төслийг "Төсвийн тухай" хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолууд, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас явуулсан загвар маягтаар зардал тус бүрээр тооцон төсөвлөлөө. Цаг уур орчны технологийн хэлтэс болон мэдээлэл үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын төсөвт тусгах саналыг хэлтсийн дарга нараар нэгтгүүлэн, Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн албан хаагчдын саналыг хэлтсийн албан хаагчдаас авч холбогдох зардлуудад тусгалаа. Нийт 3,094,039.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд, 4,103,000.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, шинээр зайлшгүй батлуулах зардалд тавилга эд хогшлийн зардалд 50,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 31,502,5 мянган төгрөгийг тус тус төлөвлөлөө. Өөрийн орлогын төлөвлөгөөг 650.0 мянган төгрөг буюу 2024, 2025 оны төлөвлөгөөгөөр төсөвлөсөн. Зарим зардлын задаргааг танилцуулбал:

1. Нэмэгдэл цалинд цаг уурын станцын ажилчдын илүү цагийг 1 сард 8-16 цагаар, харуулын ажиглагч нарын илүү цагийг 16 цагаар, нисэхэд урьдчилсан мэдээгээр үйлчилсний нэмэгдлийг илүү цагаар, ур чадварын нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл, нууцын нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдлүүдийг тухайн нэмэгдлийн нэршилээр төлөвлөсөн. Ээлжийн ажилчдад олгодог шөнийн цагийн нэмэгдэл, ёс зүйн хорооны нэмэгдэл, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны нэмэгдэл, БОШЛ-ийн хөтөлбөрт бус шинжилгээний нэмэгдэл зэрэг нь цалингийн тооцоолол төлөвлөх хүснэгтэнд байдаггүй учраас бусад гэсэн нэмэгдэлд төлөвлөлөө.
2. Хоол унааны хөнгөлөлтийн хувьд яамнаас Улаанбаатар хотод өдрийн 20.0 мянган төгрөгөөр, аймгийн төвд 15.0 мянган төгрөгөөр, суманд 10.0 мянган төгрөгөөр тооцон томъёолсон учраас тухайн дүнгээр,
3. Үр дүнгийн урамшууллын хувьд мөн сарын 16.6 хувиар тооцохоор томъёолсны дагуу,
4. Шуудан холбоо интернетийн төлбөр, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардалд нэмэлтээр БОШЛ-ийн агаарын чанарыг хянах харуулын байрны урсгал зардлыг, мөн Эрдэнэмандал, Төвшрүүлэх цаг уурын өртөөдийн шинэ барилгын халаалт, цэвэр усны зардлыг нэмж,
5. Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад жилд 1 удаа түлээ нүүрсний хөнгөлөлт олгохоор, дотоод журамд заасан тэтгэмж, тусламж олгох зардлыг,
6. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд БОШЛ-ийн 2 албан хаагчийн "Үндэсний итгэмжлэлийн төв"-өөс зохион байгуулдаг стандартын сургалтанд

- хамруулахаар, нийт Ус, цаг уурын ажилтан албан хаагчдын нэгдсэн сургалтыг танхимаар 2 хоногийн хугацаатай сургалтанд хамруулаар холбогдох зардлыг,
7. 2026 онд өндөр насны тэтгэвэрт гарахаар өргөдлөө өгсөн Б.Сүнжидмаа, 3.Амаржаргал нарын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг,
 8. Нэр дурьдагдаагүй зардлуудын хувьд өмнөх онуудын гүйцэтгэл, албан хаагчдаас ирүүлсэн хэрэгцээ шаардлагын дагуу үнэ тарифын судалгаанд үндэслэн,
 9. Бараа үйлчилгээний бусад зардалд албан хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах зардал болон 2026 онд төлөвлөгдсөн цалингийн нийт зардлын 1 хувиар ахмадын санд төвлөрүүлэхээр
 10. Тавилга эд хогшлын зардлын хувьд 2015 оноос хойш төсөв батлагдаагүй бөгөөд албан хаагчдын ширээ, сандал, сейф зэргийг зайлшгүй шинэчлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн тус тус тооцон төсвийн төслийг бэлтгэлээ.

2026 оны төсвийн төслийн нийт урсгал үйл ажиллагааны зардлын дүнг 2025 оны батлагдсан төсвөөс 349,812.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөлөө.

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН:

ЗАХИРГАА, САНХҮҮ АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  Г.ГЭРЭЛМАА

Мэдээллийн эх сурвалж: Ерөнхий нягтлан бодогч Г.Гэрэлмаа

Холбоо барих утас: +97699188846

УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ



Web site:

<https://arkhangai.weather.gov.mn/>

<https://arkhangai.namem.gov.mn/>



Facebook page:

**Архангай аймгийн Ус, цаг уур,
орчны шинжилгээний төв**



Имэйл хаяг:

info@arkhangai.namem.gov.mn



Холбоо барих:

Утас ажил: 70332095

Сүлжээ веб сайт хариуцсан ерөнхий технологич инженер

Холбоо барих утас: +97699558751